



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/97/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Баасанбат Утас: 96442101 Цахим хаяг: baasan_bataa@gmail.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

1. Аудитын гэрчилгээ э/х хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1. Залруулсан алдаа	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/85

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА С.БАТНЯМ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82.935.087.71	160.632.995.19
33	АВЛАГА	37.050.70	46.434.705.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	37.050.70	438.205.60
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	45.996.500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82.898.037.01	114.198.289.59
351	Түүхий эд материал	35.072.551.00	64.243.341.60
35110	Тусгай зориулалттай материал	28.526.249.00	42.364.245.20
35130	Эм боох материал	6.546.302.00	21.879.096.40
354	Хангамжийн материал	43.992.986.01	46.122.447.99
35410	Бичиг хэргийн материал	699.400.00	1.222.500.00
35420	Аж ахуйн материал	36.743.683.01	41.536.297.99
35430	Сэлбэг хэрэгсэл	66.000.00	66.000.00
35440	Түлш, шатах тослох материал	800.000.00	00.00
35450	Барилгын засварын материал	1.026.500.00	1.026.500.00
35460	Хүнсний материал	486.903.00	1.372.650.00
35470	Бусад хангамжийн материал	4.170.500.00	898.500.00
35600	Мал амьтад	3.832.500.00	3.832.500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	401.237.038.12	400.136.432.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	401.237.038.12	400.136.432.06
392	Биет хөрөнгө	393.101.038.12	392.000.432.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	344.642.898.29	344.642.898.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-34.601.158.92	-49.405.338.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70.236.434.00	40.500.000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24.693.217.08	-16.875.000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100.393.977.00	145.977.230.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-67.019.283.48	-76.869.598.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9.259.841.00	9.499.041.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5.118.452.69	-5.468.801.41
393	Биет бус хөрөнгө	8.136.000.00	8.136.000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8.136.000.00	8.136.000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	484.172.125.83	560.769.427.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15.569.389.30	1.606.514.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15.569.389.30	1.606.514.80
413	Өглөг	15.569.389.30	1.606.514.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1.898.878.20	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12.733.011.10	1.606.514.80
4136	Бусад өглөг	937.500.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	937.500.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	468.602.736.53	559.162.912.45
51	Засгийн газрын хувь оролцоо	468.602.736.53	559.162.912.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	259.003.817.00	267.139.817.00
51101	Өмч: - төрийн	259.003.817.00	267.139.817.00
512	Хуримтлагдсан үр дүн	-98.007.654.81	-7.447.479.32
51210	Өмнөх үеийн үр дүн	-98.007.654.81	-98.007.655.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	90.560.175.92

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	307.606.574.34	299.470.574.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	484.172.125.83	560.769.427.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	519.646.581.20	921.181.602.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49.586.845.20	58.659.155.09
120	Нийтлэг татварын бус орлого	49.586.845.20	58.659.155.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49.586.845.20	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49.586.845.20	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		38.108.953.91
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		20.550.201.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	470.059.736.00	862.522.447.71
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	371.902.500.00	434.966.900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24.007.936.00	378.145.264.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17.987.436.00	82.284.064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6.020.500.00	4.906.200.00
131107	нэмэлт		290.955.000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31.930.900.00	30.714.813.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31.930.900.00	30.714.813.71
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	42.218.400.00	18.695.470.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42.218.400.00	18.695.470.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	508.728.656.01	817.855.234.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	508.728.656.01	817.855.234.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	479.945.418.01	794.932.902.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298.569.614.00	336.189.661.27
210101	Үндсэн цалин	214.872.562.21	206.861.595.27
210102	Нэмэгдэл	62.411.734.63	91.576.405.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5.594.661.00
210104	Урамшуулал	21.285.317.16	32.157.000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38.046.694.50	48.514.024.80
210201	Тэтгэврийн даатгал	26.148.435.55	29.998.322.00
210202	Тэтгэмжийн даатгал	3.248.487.30	3.441.800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.411.404.84	2.753.300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	567.139.89	688.300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5.671.226.92	11.632.302.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28.945.051.00	32.080.594.54
210301	Гэрэл, цахилгаан	2.089.651.00	3.423.154.54
210302	Түлш, халаалт	26.749.800.00	28.533.120.00
210303	Цэвэр, бохир ус	105.600.00	124.320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25.115.148.00	28.723.597.39
210401	Бичиг хэрэг	2.235.960.00	2.533.200.00
210402	Тээвэр, шатахуун	18.685.600.00	22.536.300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2.044.988.00	2.085.707.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1.785.100.00	1.123.390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	363.500.00	445.000.00
2105	Нормативт зардал	39.028.176.64	102.273.620.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33.946.575.30	93.169.020.30
210502	Хоол, хүнс	5.081.601.34	9.104.600.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2.925.000.00	1.829.500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1.450.000.00	00.00
210604	Урсгал засвар	1.475.000.00	1.829.500.00
2107	Томилолт, зочны зардал	1.439.400.00	172.000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	64.000.00
210702	Дотоод албан томилолт	1.439.400.00	108.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38.800.00	202.749.110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38.800.00	202.749.110.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45.837.533.87	42.400.794.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13.811.765.00	8.243.927.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32.025.768.87	34.156.867.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28.783.238.00	22.922.331.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	16.149.636.00	22.861.660.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16.149.636.00	12.261.660.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	10.600.000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2.726.349.00	19.221.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1.385.849.00	00.00
213404	Хөрөнгийн	1.340.500.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9.907.253.00	41.450.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9.907.253.00	41.450.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10.917.925.19	103.326.368.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	12.766.192.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	12.766.192.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-12.766.192.80
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10.917.925.19	90.560.175.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	470.059.736.00	816.525.947.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	470.059.736.00	816.525.947.71
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	371.902.500.00	434.966.900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24.007.936.00	332.148.764.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17.987.436.00	82.284.064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6.020.500.00	4.906.200.00
131107	нэмэлт		244.958.500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31.930.900.00	30.714.813.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31.930.900.00	30.714.813.71
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	42.218.400.00	18.695.470.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42.218.400.00	18.695.470.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	456.810.736.00	808.812.447.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456.810.736.00	808.812.447.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	428.014.098.00	726.467.712.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296.554.522.00	335.335.373.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	212.857.470.21	206.097.307.00
210102	Нэмэгдэл	62.411.734.63	91.576.405.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5.594.661.00
210104	Урамшуулал	21.285.317.16	32.067.000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38.194.944.00	43.765.122.00
210201	Тэтгэврийн даатгал	26.547.100.00	29.998.322.00
210202	Тэтгэмжийн даатгал	2.965.900.00	3.441.800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.372.600.00	2.753.300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	534.008.00	688.300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5.775.336.00	6.883.400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28.945.051.00	30.714.813.71
210301	Гэрэл, цахилгаан	2.089.651.00	2.057.373.71
210302	Түлш, халаалт	26.749.800.00	28.533.120.00
210303	Цэвэр, бохир ус	105.600.00	124.320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24.311.688.00	21.635.797.39
210401	Бичиг хэрэг	1.430.488.00	1.198.300.00
210402	Тээвэр, шатахуун	18.400.400.00	15.800.600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2.024.000.00	2.095.157.39
210404	Ном, хэвлэл	00.00	370.000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1.997.400.00	1.645.390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	459.400.00	526.350.00
2105	Нормативт зардал	17.137.928.00	41.788.000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10.719.400.00	37.004.400.00
210502	Хоол, хүнс	3.993.528.00	4.783.600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2.425.000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3.660.000.00	1.433.500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2.060.000.00	00.00
210604	Урсгал засвар	1.600.000.00	1.433.500.00
2107	Томилолт, зочны зардал	1.439.400.00	172.000.00
210702	Дотоод албан томилолт	1.439.400.00	172.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1.605.400.00	242.581.979.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1.205.400.00	242.131.979.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400.000.00	450.000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16.165.165.00	9.041.127.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16.165.165.00	9.041.127.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28.796.638.00	82.344.735.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	16.163.036.00	82.284.064.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16.163.036.00	47.684.064.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	34.600.000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2.726.349.00	19.221.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1.385.849.00	00.00
213404	Хөрөнгийн	1.340.500.00	19.221.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9.907.253.00	41.450.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9.907.253.00	41.450.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13.249.000.00	7.713.500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13.249.000.00	7.713.500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13.249.000.00	7.713.500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13.249.000.00	7.713.500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13.249.000.00	7.713.500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13.249.000.00	-7.713.500.00
7	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

8	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	00.00	00.00
9	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259.003.817.00	307.606.574.34	-98.007.654.81	00.00	468.602.736.53
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	259.003.817.00	307.606.574.34	-98.007.654.81	00.00	468.602.736.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-00.43	00.00	-00.43
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259.003.817.00	307.606.574.34	-98.007.655.24	00.00	468.602.736.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-8.135.999.57	00.00	00.00	-8.135.999.57
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	8.136.000.00	00.00	00.00	00.00	8.136.000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	90.560.175.92	00.00	90.560.175.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	267.139.817.00	299.470.574.77	-7.447.479.32	00.00	559.162.912.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	525.330.700.00	484.335.733.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525.330.700.00	484.335.733.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525.330.700.00	484.335.733.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344.172.600.00	335.335.373.00
210101	Үндсэн цалин	213.780.300.00	206.097.307.00
210102	Нэмэгдэл	92.319.300.00	91.576.405.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6.006.000.00	5.594.661.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46.463.300.00	43.765.122.00
210201	Тэтгэврийн даатгал	32.696.500.00	29.998.322.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47.803.400.00	30.714.813.71
210301	Гэрэл, цахилгаан	3.569.000.00	2.057.373.71
210302	Түлш, халаалт	43.834.400.00	28.533.120.00
210303	Цэвэр, бохир ус	400.000.00	124.320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22.336.600.00	21.635.797.39

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	1.200.000.00	1.198.300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2.101.000.00	2.095.157.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2.000.000.00	1.645.390.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	865.000.00	526.350.00
2105	Нормативт зардал	45.814.400.00	41.788.000.00
210502	Хоол, хүнс	6.300.000.00	4.783.600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2.510.000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1.500.000.00	1.433.500.00
210604	Урсгал засвар	1.500.000.00	1.433.500.00
2107	Томилолт, зочны зардал	1.457.100.00	172.000.00
210702	Дотоод албан томилолт	1.457.100.00	172.000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15.333.300.00	9041.127.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15.333.300.00	9.041.127.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	525.330.700.00	484.335.733.10
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	434.966.900.00	434.925.449.39
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	434.966.900.00	434.925.449.39
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47.803.400.00	30.714.813.71
132001	Орон нутгийн төсвөөс	47.803.400.00	30.714.813.71
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42.560.400.00	18.695.470.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42.560.400.00	18.695.470.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	58.301.00
620001	Удирдах ажилтан	01.00	7.878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	4.545.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	45.878.00

2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2			
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН			
/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24.007.936.00	332.148.764.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24.007.936.00	332.148.764.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		53.861.321.17
210101	Үндсэн цалин		53.861.321.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		14.178.896.00
210201	Тэтгэврийн даатгал		14.178.896.00
210301	Гэрэл, цахилгаан		1.365.781.00
2104	Хангамж, бараа материалын зардал		9.535.250.00
210401	Бичиг хэрэг		1.384.500.00
210402	Тээвэр, шатахуун		4.371.200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		2.720.000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1.059.550.00
2105	Нормативт зардал	1.180.000.00	163.464.031.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1.180.000.00	148.400.301.00
210502	Хоол, хүнс		15.063.730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5.299.000.00	5.314.500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5.299.000.00	3.169.800.00
210602	Тавилга		378.700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1.766.000.00
2107	Томилолт, зочны зардал		645.000.00

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт		645.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	388.000.00	1.480.700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	388.000.00	1.480.700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17.490.136.00	82303285.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17.490.136.00	82303285.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16.149.636.00	47.684.064.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		34.600.000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1.340.500.00	19.221.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24.007.936.00	332.148.764.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24.007.936.00	332.148.764.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17.987.436.00	82.284.064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6.020.500.00	4.906.200.00
131107	нэмэлт		244.958.500.00
8	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	00.00	00.00
9	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч С.Батням нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч С.Байгалмаа нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэцогт сумын ЭМТ нь Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй зарчмаар стандартын дагуу чанартай тэгш, шударга жигд хүргэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 35 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 508,728.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,630.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,723.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 9,200.8 мянган төгрөг буюу 1,569.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын санхүүжилтийн 244,3958.5 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 45,996.5 мянган төгрөгийг үр дүнгийн тайланг орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 560,769.4 мянган төгрөг болж өмнөх оноос 76,597.3

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

мянган төгрөгөөр буюу 15,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82.935.1	160.633.0	77.697.9
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	37.1	46.434.7	46.397.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	82.898.0	114.198.3	31.300.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН			
Үндсэн хөрөнгө	401.237.0	400.136.4	(1.100.6)
Хуримтлагдсан элэгдэл	(131.432.1)	(148.618.7)	(17.186.6)
Нийт хөрөнгө	484.172.1	560.769.4	76.597.3
Өр төлбөр	15.569.4	1.606.5	(13.962.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	468.602.7	559.162.9	90.560.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	484.172.1	560.769.4	76.597.3

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлангаас

Бараа материалын дансны үлдэгдэл 114,198.3 мянган төгрөг болж 31,300.3 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 13,838.0 мянган төгрөгөөр, эм боох материалын дансны үлдэгдэл 15,332.7 мянган төгрөг, аж ахуйн материал 4,792.6 мянган төгрөг болж тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна. Энэ нь Ковид -19 цар тахалтай холбоотой хамгаалах хэрэгсэл, эмийн нөөцийг нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр бэлтгэсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 46,397.7 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын сангаас авах Ковид-19 өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилт дутуу байгаатай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 1,606.5 мянган төгрөг болж өмнөх оноос 13,962.9 мянган төгрөгөөр буурсан байна. ЭМДС-ийн санхүүжилт дутуу орсонтой холбоотой 1,606.5 мянган төгрөгийн эмийн өглөг үүсжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 548,755.2 мянган төгрөг болж 16,086.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 7,474.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 239.2 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авч, 30,608.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ЭМГ-аас үнэ төлбөргүй нийлүүлэгдэж, 7,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авч, Аймгийн ИТХ тэргүүлэгчдийн 2021.04.15-ний 60 тоот тогтоолоор 29,736.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг Баянхонгор аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 559,162.9 мянган төгрөг болж 90,560.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал, тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн байна. Тайлант онд 525,330.7 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 525,330.7 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 434,966.9 мянга, орон нутгийн төсвөөс 47,803.4 мянган төгрөг, ЭМДС-гаас 42,560.4 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 434,966.9 мянга, орон нутгийн төсвөөс 30,714.8 мянга, ЭМД-аас 18,695.5 мянга, нийт 484,377.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 484,335.7 мянган төгрөгийг зарцуулж, 41.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 17,088.6 мянган төгрөгөөр, ЭМД-аас авах санхүүжилтийг 23,864.9 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 484,335.7 мянган төгрөг буюу 92,2 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардлыг 11,535.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 17,88.6 мянга, нормативд зардлыг 4,026.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 332.148.7 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан байна. Нийт төвлөрсөн орлогын 244,958.5 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Ковид-19 цар тахлын хүрээнд СОК-ын шийдвэрийн дагуу тусгаарлан ажиглах байрыг Соёлын төвд 36 ортой, Эрүүл мэндийн төвд 16 нийт 50 ортойгоор, тусгаарлан ажиглах байрыг спорт зааланд 50 ортойгоор тус тус сумын Онцгой комиссын даргын шийдвэрээр байгуулан эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл зэргийн нөөцийг бүрдүүлэн ажилласан 2021 онд 410 хүнийг хэвтүүлэн, 108 хүнийг гэрийн тусгаарлалтад авч эмчилсэн байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Баянташаагийн эх аудит” ХХК-ийн аудитор Ч.Чимгээ санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 төрлийн 19 ажлыг тусган хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд хэрэгжилт 84.2%-тай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 817,855.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 309,126.6 мянган төгрөгөөр буюу 60,8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь нормативд зардал 63,245.4 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 163,949.1 мянган төгрөгөөр өссөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрх тогтоолд хамаарахгүй болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 15,800.6 мянган төгрөгийн шатах тослох материалыг худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ харьцуулалтын аргаар тендерийг зарлаж, НИК ХХК-тай гэрээг байгуулсан байна. Эмийн худалдан авалтын тендерийг аймгийн ЭМГ-аас системийн хэмжээгээр нэгдсэн журмаар зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Зөрчилгүй санал дүгнэлт авсан. Аудитаар 35,927.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 323.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 20,035.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 15,569.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсний хэрэгжилтийг 2021.06.17-ны 20 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 45,996.5 мянган төгрөгийн авлага, 1,606.5 мянган төгрөгийн өглөг үүссэн ба түүний барагдуулалт зарцуулалтыг шалгах. Цаашид хүн амын өвчлөлтэй холбоотой санхүүгийн тайланд үүсэж байгаа өглөг авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд байгууллагын болон орон нутгийн удирдлага хамтран анхаарч ажиллах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,587.9 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрч, санхүүгийн тайланд залруулав.

4.1. Залруулсан алдаа .

4.1.1 Горим сорил гүйцэтгэх явцад дараах алдаа илрэв. Үүнд:

- Илүү олгосон цалингийн суутгал 1,024.5 мянган төгрөгөөр цалингийн санг бууруулаагүй, өглөгөөр тусгасан.

- ЭМГ-аас авсан тендерийн эмийн 1,606.5 мянган төгрөгийн үлдэгдэл эмийн санд үлдэгдлээр байхад нярвын тайлан, нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй, 187.3 мянган төгрөгийн эм, боох материалыг нярвын тайланд дутуу орлого авсан

- Татварын хэлтэст цалингийн санг 26,061.3 мянган төгрөгөөр дутуу мэдээлснээс ХХОАТ-ын авлагыг санхүүгийн тайланд 633.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан.

- Хөрөнгийн дахин үнэлгээ данс Э- тайлангаас 8,136.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “ Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.” гэснийг үндэслэн санхүүгийн тайланд залруулав.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв	4	11,587.9	4	11,587.9	0	0,00	0	0,00	0	0,00

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____